# СЭЛЭНГЭ АЙМГИЙН ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 07 сарын 18 өдөр Дугаар 04 Сүхбаатар сум

2025 оны 2 дугаар улиралд хийсэн санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын дүнгийн тухай

Төсвийн тухай хуулийн 69.3, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан "*Дотоод аудитын дүрэм*"-ийн 7.7, Сангийн Сайдын 2019 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "*Дотоод аудитын хорооны дүрэм*"-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан Сэлэнгэ Энергио, Туулын Хишиг,Төгөлдөр Ерөө, Хүдэр сумын ой анги зэрэг ОНӨААТҮГ-ын болон Шаамар,Орхон сумын ТТЗ-ийн 2023,2024 оны үйл ажиллагаанд дотоод аудит, Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар, Орхон, Баянгол сумын Засаг даргын Тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Шаамар сумын Дулаанхан тосгон, Мандал сумын Хараа бүсийн сум дундын ой ангийн 2023, 2024 онуудын санхүүгийн үйл ажиллагаанд тус тус хийсэн санхүүгийн хяналт шалгалт, шилэн дансны 3 улирлын дотоод аудитаар илэрсэн зөрчлийн дүн, дүгнэлтийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг тогтоосон хугацаанд бүрэн арилгах, байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, үйл ажиллагааны дотоод хяналтыг сайжруулах чиглэлээр өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж, төсвийн сахилга бат, үр ашиг, үр нөлөө, ил тод байдлыг хангаан ажиллах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг зөвлөсүгэй.

Санхүүгийн хяналт шалгалт,дотоод аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг тогтоосон хугацаанд бүрэн арилгах, байгууллагын үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг Орон нутгийн өмчит ААТҮГ-ын захирал, төсвийн байгууллагын дарга нарт даалгасугай.

Гурав. Дотоод аудитын хорооны тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нарийн бичгийн дарга (Т.Мөнхзул)-д үүрэг болгосугай.

Хорооны дарга: Н.Лхагвадорж
(Аймгийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: T.Мөнхзул
(Ахлах дотоод аудитор)

Гишүүд: Т.Одсүрэн
(Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга)

Ө.Сувдаа
(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Б.Энхтуяа
(Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга)

Б.Янжинлхам
(Хууль эрх, зүйн хэлтсийн дарга)

А.Дашбат
(Иргэний төлөөлөл)

А.Гэрэлмаа
(Иргэний төлөөлөл)

Дотоод аудитын хорооны 2025 оны 7 дугаар сарын 18-ны
өдрийн 4 дугаар тогтоолын хавсралт

# ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ

(мян.төг)

| д/д | Байгууллагын нэр | Илэрсэн зөрчлийн дүн | Эрсдэлийн үнэлгээ |
|---|---|---|---|
| 1 | Сэлэнгэ Энерго ОНӨААТҮГ | 92,731.5 | **“Сайжруулах шаардлагатай”** |
| 2 | Туулын Хишиг ОНӨААТҮГ | 316,812.9 | “Дунд” эрсдэлтэй |
| 3 | Төгөлдөр Ерөө ОНӨААТҮГ | 1,319,983.9 | **“Хангалтгүй”** |
| 4 | Шаамар сумын Засаг дарга | 135,143.0 | **“Сайжруулах шаардлагатай”** |
| 5 | Орхон сумын Засаг дарга | 811,667.7 | ““Сайжруулах шаардлагатай” |
| 6 | Хүдэр сумын Ой анги ОНӨААТҮГ | 17,827.0 | “Бага” эрсдэлтэй |
| 7 | Мандал сумын Хараа бүсийн сум дундын ойн анги | 517,3 | “Дунд” эрсдэлтэй |
| 8 | Сэлэнгэ аймгийн Засаг даргын газар | 1,276,401.5 | Их” эрсдэлтэй |
| 9 | Орхон сумын Засаг даргын тамгын газар | 45,918.0 | “Дунд” эрсдэлтэй |
| 10 | Орхон сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал | 6,069.3 | “Дунд” эрсдэлтэй |
| 11 | Шаамар сумын Дулаанхан тосгоны Захирагчийн алба | 33,260.0 | “Дунд” эрсдэлтэй |
| 12 | Баянгол сумын Засаг даргын Тамгын газар | 388,498.0 | Дунд” эрсдэлтэй |
| 13 | Баянгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал | | Дунд” эрсдэлтэй |
| 14 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | | |
| **Дүн** | | **4,444,831.0** | |

ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ИРЦИЙН БҮРТГЭЛ

| д/д | Хорооны гишүүдийн нэрс | Албан тушаал | Гарын үсэг |
|---|---|---|---|
| 1 | Н.Лхагвадорж | Сэлэнгэ аймгийн Засаг дарга | |
| 2 | Т.Одсүрэн | Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга | |
| 3 | Ө.Сувдаа | Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга | |
| 4 | Б.Энхтуяа | Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга | |
| 5 | Б.Янжинлхам | Хууль эрх, зүйн хэлтсийн дарга | |
| 6 | А.Гэрэлмаа | Иргэний төлөөлөл /Мэдээлэл аудит ХХК-ийн Сэлэнгэ салбарын менежер/ | |
| 7 | А.Дашбат | Иргэний төлөөлөл /Монголын Мэргэшсэн нягтлан бодогч/ | |

ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ИРЦИЙН БҮРТГЭЛ

| д/д | Хорооны гишүүдийн нэрс | Албан тушаал | Гарын үсэг |
|---|---|---|---|
| 1 | Н.Лхагвадорж | Сэлэнгэ аймгийн Засаг дарга | |
| 2 | Т.Одсүрэн | Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга | |
| 3 | Ө.Сувдаа | Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга | |
| 4 | Б.Энхтуяа | Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга | |
| 5 | Б.Янжинлхам | Хууль эрх, зүйн хэлтсийн дарга | |
| 6 | А.Гэрэлмаа | Иргэний төлөөлөл /Мэдээлэл аудит ХХК-ийн Сэлэнгэ салбарын менежер/ | |
| 7 | А.Дашбат | Иргэний төлөөлөл /Монголын Мэргэшсэн нягтлан бодогч/ | |